



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/134

Бор-Өндөр сум

**Засаг даргын нөөцөөс хөрөнгө
зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Өрхийн эмч, мэргэжилтний хөгжил, дэвшил” говь-зүүн бүсийн зөвлөгөөний зардалд 1,700,000 (нэг сая долоон зуун мянга) төгрөг, Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл доор зохион байгуулагдах “Тийболлын улсын аварга шалгаруулах” тэмцээнд явах 2 багш, 15 хүүхдийн замын зардал болох 700,000 (долоон зуун мянга) төгрөг, Говийн бүс “Ёохор хатираа 2025” бүжгийн тэмцээний үйл ажиллагааны зардалд 1,000,000 (нэг сая) төгрөг, “Зүүн бүсийн үсчин гоо засалч, хумс урлаачдын аварга шалгаруулах” тэмцээний зардалд 1,000,000 (нэг сая) төгрөг, Эх үрсийн баярын анносны зардалд 300,000 (гурван зуун мянга) төгрөг, Ерөнхий боловсролын Бор-Өндөр сургуулийн спорт заалны “Волейболын торны суурь” авахад 1,100,000 (нэг сая нэг зуун мянга) төгрөг нийт 5,800,000 (таван сая найман зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 5,800,000 (таван сая найман зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих хууль, дүрмийн дагуу зарцуулахыг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ